



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 7/11

Улаанбаатар хот


Коронавирус (NCOV)-ийн шинэ хэв шинжээр  
үүсгэгдсэн халдвараас сэргийлэх бэлэн  
байдлыг ханган ажиллах тухай

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/508 тоот тушаал, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/108 тоот захирамж, Хан-Уул дүүргийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01 тоот шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Томуу, томуу төст өвчний өвчлөл болон Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлыг тогтмол зохион байгуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ, яаралтай тусламжийн болон шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгаарлах өрөө, орны нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангаж ажиллахыг хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч /Б.Шинэхүү/-д даалгасугай.
2. Халдварт өвчний тохиолдлыг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний тандалтын журмын дагуу Шинэ коронавируст халдварын болзошгүй тохиолдлыг эрт илрүүлж, коронавируст халдварын тохиолдлын тархвар судалгааны хуудсаар мэдээлэх, халдварын сэргийлэлт, хяналтын багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эмнэлгийн халдварын сэргийлэлт, хяналтын дэглэмийг чанд мөрдөх, сэжигтэй тохиолдлын үед өвчтөн болон ойрын хавьтагсаас сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэлтэнд ЭМС-тушаал, зөвлөмжийг мөрдөж ажиллах, Эрүүл мэндийн зөвлөгөө, халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах, албан хаагчид, үйлчлүүлэгчдийг гараа халдваргүйжүүлэх нөхцөлөөр хангах, амны хаалтын хэрэглээг хэвшүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг ахлах тархвар судлаач /С.Өлзийжаргал/-д даалгасугай.
3. Томуу, томуу төст өвчний өвчлөл, тархалт Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж, сэрэмжлүүлгийг иргэд, хамт олон, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд түгээх, мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг өргөнөөр зохион байгуулах, Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ, халдварын сэргийлэлт хяналтын багийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

4. Шинэ коронавирусийн халдварын болзошгүй тохиолдлын үед Олон улсын хөл хориот, Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөөний дагуу бэлтгэл, бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгслийн холбогдолтой зардлыг зохих данснудаас гаргаж нөөц бүрдүүлэхийг Ерөнхий нягтлан бодогч /С.Оюунцэцэг/-д үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмчилгээ эрхлэсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ